

*Барилга, Дэд Бүтцийн Олон Улсын Арбитрын
Удирдах зөвлөлийн 2025 оны 1/24 дүгээр
тогтоолын нэгдүгээр хавсралт*

**БАРИЛГА, ДЭД БҮТЦИЙН ОЛОН УЛСЫН
АРБИТРЫН АРБИТЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ**

АРБИТРЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

НЭГ. ЗОРИЛГО

- 1.1. Энэ дүрмийн зорилго нь Барилга, Дэд Бүтцийн Олон Улсын Арбитрын /цаашид “арбитр” гэх/ арбитражийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тодорхойлж, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай хэргийн талуудын гомдол болон холбогдох бусад этгээдийн мэдээллийг хянан шийдвэрлэх, ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон тохиолдолд хариуцлага хүлээх, арбитраж итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, арбитражийн хараат бус байдлыг хангахад оршино.
- 1.2. Монгол Улсын Үндсэн хууль, Арбитрын тухай хууль, Барилга, дэд бүтцийн олон улсын Арбитрын ажиллагааны дүрэм, талуудын сонгосон арбитраж хэрэг хянан шийдвэрлэх дүрэм нь энэхүү дүрмийн эрх зүйн үндэс байна.
- 1.3. Энэхүү ёс зүйн дүрэм нь арбитражаар ажиллахыг зөвшөөрсөн цагаас эхлэн арбитраж ажиллагааны бүх үе шат болон арбитражийн ажил хэргийн харилцаанд мөрдөгдөнө. Түүнчлэн арбитраж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй үед мөн хамаарна.

ХОЁР. АРБИТРЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

- 2.1. Нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны хэм хэмжээг үлгэрлэн сахиж, хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, үнэнч шударга, хараат бус, бие даасан, аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас, адил тэгш хандах, мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх, нууц задруулахгүй байх нь арбитражийн үйл ажиллагааны үндсэн зарчим байна.

ГУРАВ. ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ

- 3.1. Энэхүү дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн арбитражийн үйлдэл, эс үйлдлийг ёс зүйн зөрчил гэж үзнэ.
- 3.2. Ёс зүйн ноцтой зөрчил гэдэгт энэхүү дүрмээр арбитражид үүрэг болгосон буюу хориглосон хэм хэмжээг зөрчсөнийг ойлгоно. */Эргэлзээгүй байх үүднээс, энэхүү дүрэмд “үүрэгтэй” буюу “хориглоно” гэж заасан зүйл, заалт үүнд байна/*
- 3.3. Арбитрийн мэргэжлийн ур чадвар, дадлага, туршлага болоод арбитраж шийдвэрийн агуулга нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй.
- 3.4. Арбитраж нь энэхүү дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн бусад арбитражийн үйлдэл, эс үйлдэхгүйг үл тэвчих ба тухайн зөрчлийг мэдсэн даруйд арбитраж мэдэгдэнэ.

ДӨРӨВ. АРБИТРЫН АЖИЛЛАГААГ ШУУРХАЙ БӨГӨӨД ХУУЛЬ ДҮРМИЙН ДАГУУ ЯВУУЛАХ

- 4.1. Арбитрч нь зөвхөн хэргийн оролцогчдын /цаашид “талууд”/ өмнө төдийгүй арбитрын ажиллагаанд хариуцлага хүлээх бөгөөд арбитрын ажиллагааг шуурхай, хууль, дүрэмд нийцүүлэн явуулахын тулд ёс зүйн хэм хэмжээг сахих үүрэгтэй.
- 4.2. Арбитрч нь тухайн хэрэгт арбитрчаар томилогдсон тохиолдолд арбитрын ажиллагааг хууль, дүрэмд нийцүүлэн шуурхай явуулах ба шаардлагатай шийдвэрийг гаргахгүй байх, хуралдаанд хоцрох, таслах зэргээр арбитрын ажиллагааг саатуулахыг хориглоно.
- 4.3. Арбитрч нь Арбитрын тухай хууль, Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм, Арбитрын ажиллагааны журам, арбитрын хэлэлцээр болон бусад холбогдох баримт бичигт тодорхойлсон арбитрчийн бүрэн эрхийг хэтрүүлэх, урвуулан ашиглахыг хориглоно.
- 4.4. Арбитрч нь шийдвэр гаргах эрхээ бусдад шилжүүлэхийг хориглоно.

ТАВ. ХАРААТ БУС БАЙДАЛ, ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ АЛИВАА АШИГ СОНИРХОЛ, ХАРИЛЦААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

- 5.1. Арбитрч нь тухайн хэрэгт арбитрчаар томилогдох, арбитрчаар ажиллах болон арбитрын үндсэн шийдвэр гарснаас хойш 1 жилийн хугацаанд арбитрын ажиллагаанд нөлөөлөхүйц, шударга бус, нэг талыг барьсан гэж үзэх үндэслэл бүхий аливаа ашиг сонирхлын зөрчил (санхүү, бизнес, мэргэжил, гэр бүл болон нийгмийн харилцаанд орох гэх мэт) гаргахаас зайлсхийх үүрэгтэй.
- 5.2. Арбитрч нь аливаа маргаанд арбитрчаар томилохыг талуудаас буюу эрх бүхий этгээдээс шаардах эрхгүй бөгөөд ийнхүү санал тавихыг хориглоно.
- 5.3. Арбитрын бүрэлдэхүүнд орсон арбитрч нь тухайн маргааны талууд болон тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчдөд өмнө нь мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээ үзүүлж байгаагүй, тэдгээртэй төрөл садангийн болон ажил үүрэг, эд хөрөнгийн хувьд холбоогүй, ашиг сонирхлын зөрчилгүй байна.
- 5.4. Арбитрч нь хэргийн талуудад тэгш хандах үүрэгтэй бөгөөд хөндлөнгийн дарамт, айдаст автахгүй байхыг эрхэмлэнэ.
- 5.5. Арбитрч нь тодорхой хэрэг, хэргийн талууд, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар дараах мэдээллийг Арбитр болон хэргийн оролцогч талуудад мэдэгдэх үүрэгтэй:
 - 5.4.1. арбитраас гарах эцсийн шийдвэрт шууд болон шууд бус байдлаар санхүү, хувийн ашиг сонирхол бий эсэх;
 - 5.4.2. хараат бус байдалд нөлөөлөхүйц эсхүл тэгш бус гэж үзэх үндэслэл бүхий өмнө нь болон одоогийн санхүүгийн, бизнес, ажил мэргэжил, гэр бүл, төрөл садан болон нийгмийн бусад харилцаа холбоо бий эсэх.

ЗУРГАА. ХЭРГИЙН ТАЛУУД БОЛОН БУСАД ОРОЛЦОГЧИДТОЙ ХҮНДЭТГЭЛТЭЙ ХАРИЛЦАХ

- 6.1. Арбитрч нь талууд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, арбитрын ажиллагааны бусад оролцогчидтой хүндэтгэлтэй харилцах бөгөөд доромжлох, айлган сүрдүүлэх, заналхийлэх, ажил хэргийн нэр хүндийг гутаах, басамжлах зэрэг зүй бусаар харилцах, зан харилцааны дутагдал гаргахгүй байх үүрэгтэй.

- 6.2. Талуудын байгуулсан арбитрын хэлэлцээр, арбитрын ажиллагаанд хэрэглэх дүрэмд арбитрчаас талуудтай харилцах аливаа хэлбэр, агуулгыг тогтоож өгсөн бол арбитрч нь уг хэм хэмжээг мөрдөх үүрэгтэй.
- 6.3. Арбитрын хэлэлцээр, Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм, арбитрын ажиллагааны журамд өөрөөр заагаагүй бол арбитрч нь хэргийн аль нэг талтай харилцах тохиолдолд зөвхөн бичгээр харилцах ба хуулбарыг нөгөө талд нэгэн зэрэг хүргүүлнэ. Хэрэгтэй холбоотой аливаа бичгээр ирүүлсэн мэдээлэл нөгөө талд хүргэгдээгүй тохиолдолд арбитрч нь даруй хүргүүлэх арга хэмжээ авна.
- 6.4. Арбитрч нь арбитрын хуралдааны явцад арбитрын хуралдааны зориулалтаас бусад гар утас, харилцаа холбоо, техник технологийн хэрэгсэл ашиглахгүй байх үүрэгтэй.

ДОЛОО. НУУЦ ЗАДРУУЛАХГҮЙ БАЙХ

- 7.1. Арбитрч нь арбитрын ажиллагааны явцад өөрт нь илэрхий болсон төр, байгууллага, хувь хүний болон зөвлөлдөх тасалгааны нууцыг задруулахыг хориглоно.
- 7.2. Талууд өөрөөр тохиролцоогүй, мөн холбогдох хууль, дүрэмд өөрөөр заагаагүй бол арбитрч нь арбитрын ажиллагаа, хэргийн талууд, арбитрын шийдвэртэй холбоотой бүх мэдээллийг нууцлах үүрэгтэй.
- 7.3. Арбитрч нь хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байгаа хэрэг, маргааны талаар өөрийн санал, бодлыг урьдчилан илэрхийлэх, бусдад болон олон нийтэд мэдээлэх, амлалт өгөхийг хориглоно.

НАЙМ. ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ, ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ

- 8.1. Хэргийн талууд болон бусад оролцогчид нь арбитрч ёс зүйн зөрчил гаргаснаас хойш 6 сарын дотор, зөрчил гаргасан тухай мэдсэнээс хойш 1 сарын дотор гомдол, мэдээллийг холбогдох баримтын хамт Арбитрын ажлын албанд ирүүлнэ.
- 8.2. Хэрэгт хамааралгүй бусад иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан нь арбитрчийн ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл гаргаж болох ба ингэхдээ энэ дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасныг баримтална.
- 8.3. Гомдол, мэдээлэлд дараах зүйлсийг тусгасан байна:
 - 8.3.1. гомдол, мэдээлэл гаргагч иргэний овог, нэр, оршин суугаа газрыг хаяг, шуудангийн хаяг;
 - 8.3.2. гомдол, мэдээлэл гаргагч хуулийн этгээдийн нэр, оршин байгаа хаяг, эрх бүхий этгээдийн нэр, албан тушаал, төлөөлөгчид олгосон итгэмжлэл;
 - 8.3.3. гарын үсэг, огноо;
 - 8.3.4. гомдол, мэдээллийн үндэслэл, холбогдох баримтуудыг хавсаргана.
- 8.4. Арбитрын ажлын алба гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 72 цагийн дотор Арбитрчдын ёс зүйн хороо /цаашид “Ёс зүйн хороо” гэх/-нд мэдэгдэнэ.
- 8.5. Гомдол, мэдээллийг дараах тохиолдолд хүлээн авахгүй:
 - 8.5.1. гомдол, мэдээлэл нь тодорхой нэр хаяггүй;

- 8.5.2. энэ дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан хугацааг хэтрүүлсэн;
 - 8.5.3. энэ дүрмийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт заасан шаардлага хангаагүй;
 - 8.5.4. өмнө нь хандаж байсан асуудлаар өргөдөл, мэдээлэл гаргасан бөгөөд түүнийг дахин хянаж шийдвэрлэх үндэслэлгүй.
- 8.6. Ёс зүйн хорооны хуралдааныг зохион байгуулах, гомдол гаргагч болон гомдолд дурдсан арбитрчид мэдэгдэл хүргүүлэх, ажиллагааг ажлын алба хариуцна.

ЕС. ЁС ЗҮЙН ХОРОО БОЛОН ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ, ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

- 9.1. Арбитрын ёс зүйн хороо /“Ёс зүйн хороо”/ нь 5 гишүүнтэй байх бөгөөд Арбитрын даргын саналыг харгалзан Арбитрчдын зөвлөл хорооны гишүүнийг 3 жилийн хугацаагаар томилно.
- 9.2. Ёс зүйн хороо нь гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хэлэлцэн олонхын саналаар санал/дүгнэлтээ гарган Арбитрчдын зөвлөлд хүргүүлнэ. Хэрэв шаардлагатай гэж үзвэл гомдол, мэдээллийг хэлэлцэх хугацааг Ёс зүйн хороо нь 1 удаа 14 хоногоор сунгаж болно.
- 9.3. Ёс зүйн хороо нь гомдол, мэдээллийн талаар гомдол, мэдээлэлд дурдсан арбитрчид нэн даруй мэдэгдэнэ. Арбитрч нь мэдэгдлийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор гомдол, мэдээлэлтэй холбогдуулан тайлбараа Ёс зүйн хороонд бичгээр эсхүл цахим шуудангаар ирүүлнэ.
- 9.4. Гомдлыг хэлэлцэх ёс зүйн хорооны 3 гишүүдийг Арбитрын дарга томилно.
- 9.5. Ёс зүйн хорооны гомдол, мэдээллийг хэлэлцэх ажиллагаанд гомдол, мэдээлэл гаргагч, гомдол, мэдээлэлд дурдсан арбитрч оролцож болох бөгөөд ийнхүү хүрэлцэн ирээгүй нь Ёс зүйн хорооны санал/дүгнэлт гаргахад саад болохгүй.
- 9.6. Ёс зүйн хорооны хурлын товыг Ажлын албанаас гомдол, мэдээлэл гаргагч, гомдол, мэдээлэлд дурдсан арбитрчид боломжит хэлбэрээр, 3-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ.
- 9.7. Арбитрчдын зөвлөл нь Ёс зүйн хорооны санал/дүгнэлтийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хуралдан шийдвэр гаргана.
- 9.8. Арбитрчдын зөвлөл нь шийдвэр гаргахдаа гомдол, мэдээлэл гаргагч болон гомдол, мэдээлэлд дурдсан арбитрчийг байлцуулахгүйгээр хуралдан, шийдвэр гаргаж болно.
- 9.9. Арбитрчдын зөвлөл нь Ёс зүйн хорооноос ирүүлсэн санал/дүгнэлтэд үндэслэн, олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна
- 9.10. Арбитрчдын зөвлөлийн шийдвэрт гомдол гаргах эрхгүй.
- 9.11. Арбитрчдын зөвлөлийн тогтоол гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор гомдол, мэдээлэл гаргагч, гомдол, мэдээлэлд холбогдсон арбитрчид мэдэгдэх ажиллагааг Арбитрын ажлын алба хариуцна.

АРАВ. ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГА

- 11.1. Арбитрчдын зөвлөл арбитрч ёс зүйн зөрчил гаргасан гэж үзвэл дараах хариуцлагын аль нэгийг хүлээлгэнэ:
- 11.1.1.арбитрчид нээлттэй эсхүл хаалттай сануулах;
- 11.1.2.тухайн гомдол, мэдээлэлтэй холбоотой хэрэгт ажиллан олгосон арбитрчийн урамшууллын ... хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг хоногийн дотор буцаан гаргуулах;
- 11.1.3.арбитрчийн эрхийг түдгэлзүүлэх саналыг Барилга, дэд бүтцийн олон улсын Арбитрын Удирдах Зөвлөлийн хуралд оруулах;
- 11.1.4.арбитрчдын нэрсийн жагсаалтаас хасах саналыг Арбитрын Удирдах Зөвлөлийн хуралд оруулах.
- 11.2. Ёс зүйн зөрчлийг 1 жилийн хугацаанд давтан буюу 2 ба түүнээс дээш удаа гаргасан тохиолдолд энэхүү зүйлийн 11.1.4 дэх хэсэгт заасан хариуцлагыг ногдуулна.
- 11.3. Ёс зүйн ноцтой зөрчил гаргасан арбитрчид энэхүү зүйлийн 11.1.4 дэх хэсэгт заасан хариуцлагыг шууд ногдуулна.
- 11.4. Энэхүү дүрмийн дагуу арбитрчдын нэрсийн жагсаалтаас хасагдсан тохиолдолд тухайн хүнийг 5 жилийн хугацаагаар арбитрчийн нэрсийн жагсаалтад дахин бүртгэхгүй.

АРВАН ХОЁР. БУСАД

- 12.1. Арбитрчдын зөвлөл нь тухайн арбитрчид ёс зүйн хариуцлага ногдуулсан нь хэргийг шийдвэрлэсэн Арбитрын шийдвэрийг өөрчлөх үндэслэл болохгүй.